



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2024/48/НА-СТА-ТӨА

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Энхдалай
Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn
Ахлах аудитор: А.Даваадорж
Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Аудитор: М.Ганбаатар
Утас: 261628 Цахим хаяг: ganbaatar.m@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	8
3.1 Монгол кино нэгтгэл ТӨҮГ, түүний үйл ажиллагаа	8
3.2 Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	9
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	10
3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин	10
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	12
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4.5.1 Завсрын аудитын талаар.....	14
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
5.1 Албан шаардлага	15
5.2 Зөвлөмж.....	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	17

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/677
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 31.5 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 5.6 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол кино нэгтгэл ТӨҮГ нь “Төрөөс кино урлагийн талаар гаргасан бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, баримтлах төрийн зарим чиг үүрэг, соёлын бүтээлч үйлдвэрлэл, кино урлагийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, кино үйлдвэрлэлийн бизнесийн орчныг бүрдүүлэх, шаардлагад нийцсэн кино бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангах, кино урлагийн улсын болон олон улсын арга хэмжээ зохион байгуулах, кино үйлдвэрлэгч, бүтээгч байгууллага аж ахуйн нэгжийн идэвх санаачилгыг дэмжиж туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 74 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор “Түүхийн хүрд” баримтат киног Соёл урлагийн газартай

МОНГОЛ КИНО НЭГТГЭЛ
ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Б.ТҮМЭН-ӨЛЗИЙ ТАНАА

гэрээ байгуулан 63.4 сая төгрөгийн санхүүжилт авч 12 бүлэг баримтат киног бүтээж Үндэсний төв архивд хүлээлгэн өгч ажилласан байна.

Монгол Улсын Засгийн Газраас хэрэгжүүлж буй "Алсын хараа 2050", Соёлын сэргэлт 2023 хөтөлбөрийн хүрээнд Дархан хотноо "Кинонд ээлтэй Дархан хот" урианы доор Монголын кино урлагийн үүсэл хөгжил, Дархан хотод зураг авалт хийгдсэн киноны тухай танилцуулга хийж кино сурталчлах ажлыг 2023.09.22-23-ны өдрүүдэд Залуучууд театрт зохион байгуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 568 дугаар тогтоолоор баталсан Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын Эдийн засгийн зорилтот түвшний орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл 88.9 хувь, зардал 93.6 хувь, цэвэр ашиг 63.0 хувь, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл 50.8 хувийн гүйцэтгэлтэй, 2022 оны цэвэр ашгаас 26.1 сая төгрөгийн ноогдол ашгийг ТӨБЗГ-т төвлөрүүлсэн байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	226,423,825.19	277,658,849.33
1.1.2	Дансны авлага	20,605,089.07	24,934,430.00
1.1.4	Бусад авлага	0.00	67,405.95
1.1.6	Бараа материал	485,216,377.84	485,216,377.84
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	732,245,292.10	787,877,063.12
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,913,746,747.64	2,902,029,136.46
1.2.2	Биет бус хөрөнгө	769,428,509.47	768,978,372.80
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,683,175,257.11	3,671,007,509.26
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,415,420,549.21	4,458,884,572.38
2.1.1.1	Дансны өглөг	0.00	355,745.27
2.1.1.3	Татварын өр	1,454,849.90	2,496,488.56
2.1.1.4	НДШ - ийн өглөг	31,752.02	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,486,601.92	2,852,233.83
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,486,601.92	2,852,233.83
2.3	Өмч	145,352,055.93	145,352,055.93
2.3.1	төрийн	145,352,055.93	145,352,055.93
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,878,331,806.60	3,878,331,806.60
2.3.9	Хуримтлагдсан ашиг	390,250,084.76	432,348,476.02
2.3.11	Эздийн өмчийн дүн	4,413,933,947.29	4,456,032,338.55
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,415,420,549.21	4,458,884,572.38

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	303,592,436.32	279,164,947.91
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	49,665,589.35	51,019,907.53
3	Нийт ашиг (алдагдал)	253,926,846.97	228,145,040.38
4	Түрээсийн орлого	218,710,492.13	323,055,013.88
5	Хүүгийн орлого	0.00	4,550,605.48
8	Бусад орлого	38,212,619.03	33,095,920.95
10	Ерөнхий ба удирдлагын зардал	450,171,510.37	501,351,857.77
12	Бусад зардал	2,626,217.82	17,218,130.99
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	65,192.43	-3,575.59
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	58,117,422.37	70,273,016.34
19	Орлогын татварын зардал	5,811,742.24	7,194,035.94
20	Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	52,305,680.13	63,078,980.40
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	52,305,680.13	63,078,980.40
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	52,305,680.13	63,078,980.40

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	145,352,055.93	3,878,331,806.6	337,944,405.28	4,361,628,267.81
3	Залруулсан үлдэгдэл	145,352,055.93	3,878,331,806.6	337,944,405.28	4,361,628,267.81
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	52,305,680.13	52,305,680.13
9	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	145,352,055.93	3,878,331,806.6	390,250,085.41	4,413,933,947.94
11	Залруулсан үлдэгдэл	145,352,055.93	3,878,331,806.6	390,250,085.41	4,413,933,947.94
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.	0.	63,078,980.4	63,078,980.4
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.	0.	4,360,508.62	4,360,508.62
15	Зарласан ногдол ашиг	0.	0.	-26,152,840.	-26,152,840.
17	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	145,352,055.93	3,878,331,806.6	431,536,734.43	4,455,220,596.96

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн	611,204,190.00	699,363,620.23
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	602,749,523.00	684,169,659.03
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	14,123,215.93
1.1.6	Бусад мөнгөн орлого	8,454,667.00	1,070,745.27
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	429,787,010.94	538,467,295.98
1.2.1	Ажиллагчдад төлсөн	157,873,553.30	182,289,679.98
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	46,919,652.59	54,402,863.89
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	30,114,999.30	74,756,577.17
1.2.4	Ашиглалтын зардал төлсөн	96,758,243.84	121,969,940.67
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	7,295,700.00	11,434,198.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	82,803,894.91	74,518,510.63
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	267,300.00	356,940.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	7,753,667.00	18,738,585.64
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	181,417,179.06	160,896,324.25
2.1	Мөнгөн орлогын дүн	0.00	4,550,605.48
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	0.00	4,550,605.48
2.2	Мөнгөн зарлагын дүн	41,629,095.00	88,055,490.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	41,629,095.00	88,055,490.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-41,629,095.00	-83,504,884.52
3.1	Мөнгөн орлогын дүн	0.00	230,000.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	230,000.00
3.2	Мөнгөн зарлагын дүн	0.00	26,382,840.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	230,000.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	26,152,840.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	-26,152,840.00
4	Валютын ханшийн зөрүү	65,192.43	-3,575.59
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	139,853,276.49	51,235,024.14
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	86,570,548.70	226,423,825.19
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	226,423,825.19	277,658,849.33

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Хувь
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр /Баримтат кино/:	бүлэг	12	12	12		
1	Улсын төсвөөр хийж гүйцэтгэсэн ажил	мян.төг	92,445.8	90,000.0	63,430.8	-26,569.2	70.4
	Гэрээгээр гүйцэтгэсэн ажил /Баримтат кино/	мян.төг	6,818.2	20,000.0	38,218.1	18,218.2	-
	Соёлын бүтээлч үйлдвэрлэл хөтөлбөрөөс санхүүжих орлого		-	100,000.0	38,595.9	-61,404.1	-
	Үйлчилгээний орлого	мян.төг	204,328.5	200,000.0	138,920.00	-61,080.0	69.5
	Түрээсийн орлого	мян.төг	218,710.5	260,000.0	323,055.00	63,055.0	124.2
	Үйл ажиллагааны бусад орлого	мян.төг	38,277.8	50,000.0	37,646.50	-12,353.5	75.3
2	Нийт орлого	мян.төг	560,580.8	720,000.0	639,866.4	-80,133.6	88.8
3	Нийт зардал	мян.төг	502,463.3	608,422.7	569,593.4	-38,829.3	93.6
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	45,041.2	25,110.7	18,125.9	-6,984.8	72.2
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	58,117.5	111,577.3	70,272.9	-41,304.3	-
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	52,305.7	100,419.6	63,245.7	-37,173.9	-
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	129,170.6	147,442.6	149,856.3	2,413.7	101.6
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян.төг	-	9,193.0	26,152.8	16,959.8	284.5
8	Нийт ажиллагсадын тоо	хүн	16	17	16	-1.0	94.1
9	Нийт цалингийн сан	мян.төг	193,237.1	174,263.0	193,237.1	18,974.1	110.9
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	1,006.4	854.2	1,006.4	152.2	117.8
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	0.9	1	0.9	-0.1	89.0
12	Хөрөнгө оруулалт	мян.төг	43,604.2	45,300.0		-45,300.0	-
13	Нийт авлага	мян.төг	20,605.1	35,000.0	20,605.1	-14,394.9	58.8
	Үүнээс: Найдваргүй	мян.төг	18,000.0	18,000.0	18,000.0	0.0	100.0
14	Нийт өглөг	мян.төг	1,486.6	1,000.0	1,486.6	486.6	148.6
	Богино хугацаат өр төлбөр	мян.төг	1,486.6	1,000.0	1,486.6	486.6	148.6
	Урт хугацаат өр төлбөр	мян.төг	-	-	-	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Монгол кино нэгтгэл ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

ТӨБЗГ-ын 2022 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол кино нэгтгэл” ТӨҮГ-ын шинэчилсэн дүрэмд “Үйлдвэрийн газрын үйл ажиллагааны үндсэн зорилт нь: “Төрөөс кино урлагийн талаар гаргасан бодлого шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, баримтлах төрийн зарим чиг үүрэг, соёлын бүтээлч үйлдвэрлэл, кино урлагийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, кино үйлдвэрлэлийн бизнесийн орчныг бүрдүүлэх, шаардлагад нийцсэн кино бүтээгдэхүүнээр хэрэглэгчдийг хангах, кино урлагийн улсын болон олон улсын арга хэмжээ зохион байгуулах, кино үйлдвэрлэгч, бүтээгч байгууллага аж ахуйн нэгжийн идэвх санаачилгыг дэмжиж туслалцаа үзүүлэх” гэж тодорхойлсон байна.

Мөн үйл ажиллагааны чиглэлийг кино үйлдвэрлэлийн кластерийг хөгжүүлэх чиглэлээр олон улсын санхүүжилт дэмжлэгээр төсөл хөтөлбөр боловсруулах, хөгжүүлэх, онцгой үйл явдлыг хадгалан архивлах зорилгоор баримтат кино, мэдээ, контент бүтээх, уран сайхны, баримтат, хүүхдийн болон хүүхэлдэйн кино хийх, дуу, дүрс бичлэг, бусад контент бүтээх, кино телевиз, дүрс бичлэгийн зориулалтаар техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэлийн түрээс, үл хөдлөх хөрөнгө, байр талбайн түрээс болон хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа эрхлэх гэжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ТӨААТҮГ-ыг статустай, 100 хувь төрийн эзэмшилд байна. Шинэчилсэн дүрэмд үйл ажиллагааны үндсэн чиглэлд “Үл хөдлөх хөрөнгө, байр талбай түрээслэх” /4.2.6/ гэсэн өөрчлөлт орсноор үл хөдлөх хөрөнгийн түрээсийн үйл ажиллагаа нь тус байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиг үүрэг болсон байна.

3.2 Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Монгол кино нэгтгэл ТӨҮГ нь кино хальс боловсруулах, баримтат болон уран сайхны кино бүтээх, иргэд аж ахуйн нэгжүүдэд киноны мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаа явуулдаг, Соёлын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ нь Сайд нарын зөвлөлийн 32 дугаар тогтоолоор Улсын кино зургийн хорооны харьяа кино үйлдвэрийн газар болж үүсгэн байгуулагдсан бөгөөд ТӨБЗГ-ын 2022 оны 84 дүгээр тогтоолоор тус газрын дүрмийг шинэчлэн баталсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй” гэж заасан заалтын 5-д “хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д зааснаар “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллага нь Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Соёлын тухай хууль, Кино урлагийг дэмжих тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

- Соёлын тухай хууль
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Улсын баяр наадмын тухай хууль

ТӨҮГ-ын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, аудитыг гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус ТӨҮГ-ын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Монгол Улсын Сангийн Сайдын тушаалаар баталсан журам, заавар, аргачлалын шаардлагад нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43.4 сая төгрөгөөр буюу 1.0 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	226,423.8	277,658.8	51,235.0
Авлага	20,605.1	25,001.8	4,396.7
Бараа материал	485,216.4	485,216.4	-
Үндсэн хөрөнгө	2,913,746.7	2,902,029.1	(11,717.6)
Биет бус хөрөнгө	769,428.5	768,978.4	(450.1)
Нийт хөрөнгө	4,415,420.6	4,458,884.6	43,464.0
Өр төлбөр	1,486.6	2,852.2	1,365.6
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,413,933.9	4,456,032.3	42,098.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,415,420.6	4,458,884.6	43,464.0

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

- Мөнгөн хөрөнгийн данс өмнөх оноос 51.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны борлуулалтын орлого өссөн;
- Авлага дансны үлдэгдэлд Сэнгэдорж түшээ ХХК-аас авах 4.1 сая төгрөг, Блэк скуад ХХК-аас 1.1 сая төгрөгийг бүртгэсэн;
- Үндсэн хөрөнгө данс нь 11.7 сая төгрөгөөр элэгдэл байгуулж буурсан;
- Өр төлбөр дансны үлдэгдэл өссөн нь ААНОАТ болон НӨАТ-ын 2.5 сая төгрөг, дансны өглөг 0.3 сая төгрөгийн өр төлбөр үүссэн;
- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өсөхөд тайлант үед 43.5 сая төгрөгийн үр дүн нөлөөлсөн;

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй. ТӨБЗГ-ын 2022 оны 568 дугаар тогтоолоор 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 720.0 сая төгрөгөөр, нийт зардлыг 608.4 сая төгрөгөөр, 111.6 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 162.3 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2022 оны гүйцэтгэл	2023 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр /Баримтат кино/:	Бүлэг	12	12	12	-	-
1	Улсын төсвөөр хийж гүйцэтгэсэн ажил	мян.төг	92,445.8	90,000.0	63,430.8	(26,569.2)	70.5
	Гэрээгээр гүйцэтгэсэн ажил /Баримтат кино/	мян.төг	6,818.2	20,000.0	38,218.2	18,218.2	-
	Соёлын бүтээлч үйлдвэрлэл хөтөлбөрөөс санхүүжих орлого		-	100,000.0	38,595.9	(61,404.1)	-
	Үйлчилгээний орлого	мян.төг	204,328.5	200,000.0	138,920.0	(61,080.0)	69.5
	Түрээсийн орлого	мян.төг	218,710.5	260,000.0	323,055.0	63,055.0	124.3
	Үйл ажиллагааны бусад орлого	мян.төг	38,277.8	50,000.0	37,646.5	(12,353.5)	75.3
2	Нийт орлого	мян.төг	560,580.8	720,000.0	639,866.4	(80,133.6)	88.9
3	Нийт зардал	мян.төг	502,463.3	608,422.7	569,593.4	(38,829.3)	93.6
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	45,041.2	25,110.7	18,125.9	(6,984.8)	72.2
4	Татварын өмнөх ашиг	мян.төг	58,117.5	111,577.3	70,273.0	(41,304.3)	-
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян.төг	52,305.8	100,419.6	63,245.7	(37,173.9)	-

3.5.1 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 639.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 569.6 сая төгрөгийн зардал гарган, 70.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 639.9 сая төгрөг болж төлөвлөснөөс 80.1 сая төгрөг буюу 11.1 хувиар тасарсан нь Засгийн газрын 1997 оны 74 дүгээр тогтоолоор гүйцэтгэж, улсын төсвөөс санхүүжин бүтээгддэг “Түүхийн хүрд” баримтат киноны санхүүжилт 26.6 сая төгрөгөөр, Соёлын яамнаас хэрэгжүүлэхээр төлөвлөсөн Соёлын бүтээлч үйлдвэрлэл хөтөлбөрөөс санхүүжих үйл ажиллагааны орлого 61.4 сая төгрөгөөс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл 569.6 сая төгрөг болж, төлөвлөснөөс 38.8 сая төгрөг буюу 6.4 хувиар дутуу гүйцэтгэлтэй байгаа нь төлөвлөсөн зарим үйл ажиллагаануудыг дутуу гүйцэтгэснээс шалтгаалсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 8 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 82.5 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

Тайлант онд цэвэр ашиг 63.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 37.2 сая төгрөгөөр дутуу байгаа нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн уран бүтээл, ажил үйлчилгээний улсын төсвийн санхүүжүүлт хийгдээгүйгээс шалтгаалсан байна.

Тайлант онд 2022 оны цэвэр ашгаас 50.0 хувиар тооцон ТӨБЗГ-т 26.1 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт, хөрөнгийн бүртгэл, тайлагналыг сайжруулах, төсвийг зохистой удирдах талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-Нийцлийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор М.Ганбаатар нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 24/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн эцсийн санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 560.6 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 5.6 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус ТӨҮГ нь тайлант онд бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулаагүй, давхардсан ажлын байр бий болгоогүй, их хэмжээгээр бараа материал нөөцөлж бэлдээгүй, төрийн цахим худалдан авалтын системийг ашиглан хөрөнгийг худалдан авсан зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн 3 зөрчилд зөрчлийг арилгах 1 албан шаардлага, давтан гаргахгүй анхаарч ажиллах 2 зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол кино нэгтгэл ТӨҮГ нь тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 21 нэр төрлийн 155 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг Монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг батлуулж ажиллаагүй байна.

Энэ нь Кино урлагийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйл.Иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх бусад дэмжлэг 14.3-т "Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулна. Хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг соёл, боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг боловсруулан батлуулж **зөрчлийг арилгах албан шаардлага** хүргүүлсэн.

2. Ажилчдад Хөдөлмөрийн тухай хуулиар олгосон цалингийн нэмэгдэл урамшуулал олгодоггүй, хүний нөөцийн хэрэгцээ шаардлага тодорхойлох, ажилтныг сургах, мэргэшүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Байгууллагын дүрмийн 6.13.9-д заасан "Батлагдсан орон тооны хязгаар болон ажилчдын цалин хөлс, нэмэгдэл урамшууллыг батлагдсан цалингийн санд багтаан тогтоох, мөрдүүлэх, нийгмийн баталгааны арга хэмжээ авах ", 6.13.10-д заасан "Үйлдвэрийн газрын хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, нийтлэг үйлчилгээний чиглэлээр ажилтныг давтан сургах, мэргэшүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах" гэснийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөдөлмөрийн тухай хууль болон Байгууллагын дүрэмд нийцүүлэн нэмэгдэл цалин, урамшууллыг олгож, ажилтныг сурган, мэргэшүүлж ажиллах **зөвлөмж** хүргүүлсэн.

3. Архивын өрөө нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан стандартад нийцээгүй, цахим архив үүсгээгүй, баримт бичиг устаж алга болох эрсдэлтэй байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д "Байгууллагын архив тухайн байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, архивын баримтыг анхан шатанд бүрдүүлж, энэ хуульд заасан хугацаагаар түр хадгална", 23.2.4-т "архивын баримтыг холбогдох журам, стандартын дагуу хадгалах, хамгаалах", 23.2.6-д "архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим мэдээллийн сан бүрдүүлэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу архивын нэгжийн хадгалах нөхцөлийг бүрдүүлэх, цахим архив үүсгэх, архивын баримтын бүртгэлийг сайжруулах **зөвлөмж** хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуультай нийцсэн,

төрийн өмчийн хөрөнгийг Монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг батлуулж ажиллаагүй нь Кино урлагийг дэмжих тухай хууль, ажилчдад олгох нэмэгдэл цалин урамшуулал, ажилтныг сургах мэргэшүүлэх нь Байгууллагын дотоод дүрэм, архивын хадгалалт, хамгаалалт цахим архив бүрдүүлээгүй зэрэг нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн зарим заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн тайланд аудит хийж, байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар илэрсэн зөрчилд өгсөн 24.8 сая төгрөгийн 3 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	24,850.7	3	24,850.7	100
Нийт дүн	3	24,850.7	3	24,850.7	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Монгол кино нэгтгэл ТӨҮГ-ын үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт их засварын ажил хийгдээгүй удсан тул цаашид төрийн өмч хөрөнгийн чанар байдал муудаж, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ буурах эрсдэлтэй байгаа асуудалд Төсвийн ерөнхийлөн захирагч анхаарлаа хандуулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 31.5 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 28.7 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 2.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 31.5 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5.0 сая төгрөгөөс их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Эдийн засгийн зорилтот түвшний хүрээнд худалдан авах бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авч 28.3 сая төгрөгийн зардал гаргасан байна. Энэ нь Төрийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3-т "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох", ТӨБЗГ-ын 2022 оны 568 дугаар тогтоолын 2 дугаар хавсралттай нийцээгүй тул санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Тайлант оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйл, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналт 9-т "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэнэ" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

3. Түрээсийн гэрээгээр "Монгол" уран сайхны кинонд ашиглах жижиг хэрэгсэл, хувцас эд зүйлсийг ашиглуулсан ч эртний хийцийн эмээлийг түрээслэгч хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд ААНОАТ болон НӨАТ-ын 2.5 сая төгрөг, бусад өглөг 0.3 сая төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэж ажиллахгүй байх;

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Цаашид ашиглах боломжгүй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 71 нэр төрлийн үндсэн хөрөнгийн үнэ, ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах талаарх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна. Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ”, Байгууллагын дүрмийн 6.13.8-д заасан “Үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгө худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх асуудлыг ТӨБЗГ-т санал тавьж шийдвэрлүүлэх ” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид ашиглах боломжгүй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг актлах, данс бүртгэлээс хасах саналаа ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дугаар сарын 02 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Эдийн засгийн зорилтот түвшний хүрээнд худалдан авах бараа ажил үйлчилгээний төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авч 28,331.5 мянган төгрөгийн зардал гаргасан байн	1	28,331.5			1	28,331.5						
2	Түрээсийн гэрээгээр "Монгол" уран сайхны кинонд ашиглах жижиг хэрэгсэл, хувцас эд зүйлсийг ашиглуулсан ч эртний хийцийн эмээлийг түрээслэгч хүлээлгэн өгөөгүй байна.	1	350.0			1	350.0						
3	Тайлант оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлээгүй байна.	1	-			1	-						
4	Цаашид ашиглах боломжгүй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 71 нэр төрлийн үндсэн хөрөнгийн үнэ, ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах талаарх саналыг эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлүүлээгүй байна.	1	-					1	-				
5	Тайлант онд ААНОАТ болон НӨАТ-ын 2,496.4 мянган төгрөг, дансны өглөг 355.7 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна.	1	2,852.2					1	2,852.2				
	Дүн	5	31,533.7			3	28,681.5	2	2,852.2				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг батлуулж ажиллаагүй байна	1	-	1	-		
2	Ажилчдад хөдөлмөрийн тухай хуулиар олгосон цалингийн нэмэгдэл урамшуулал олгодоггүй, хүний нөөцийн хэрэгцээ шаардлага тодорхойлох, ажилтныг сургах, мэргэшүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	-			1	-
3	Архивын өрөө нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан стандартад нийцээгүй, цахим архив үүсгээгүй, баримт бичиг устаж алга болох эрсдэлтэй байна.	1	-			1	-
	Дүн	3	-	1	-	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 425/А0140081

Улаанбаатар хот

СНАГ-2024/48/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авч 28,331,500.00 /хорин найман сая гурван зуун гучин нэгэн мянга таван зуун/ төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т "төрийн өмчит хуулийн этгээдээс дагаж мөрдөх төлөвлөлт, ашиг орлогын хуваарилалтыг холбогдох байгууллагатай тохиролцон тогтоох", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 568 дугаар "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай тогтоолын 2 дугаар хавсралт " Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын 2023 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол албаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын захирал /Б.Түмэн-Өлзий/, ерөнхий нягтлан бодогч /Г.Төрбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ГАНБААТАР

0001300961



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 426/В0170081

Улаанбаатар хот

СНАГ-2024/48/НА-СТА - ТӨА
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг батлуулж ажиллаагүй байна.

Энэ нь Кино урлагийг дэмжих тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулна. Хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг соёл, боловсрол болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Кино зураг авах зориулалттай төрийн өмчийн барилга байгууламж, шаардлагатай тоног төхөөрөмжийг монгол болон хамтарсан кино бүтээхэд хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулах журмыг батлуулж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын захирал /Б.Түмэн-Өлзий/, ерөнхий нягтлан бодогч /Г.Төрбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ГАНБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264050

Z:\Alban Shaardlaga\2024\03\15 SNAG-1.Docx

0001003987



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 427/А0170081

Улаанбаатар хот

СНАГ-2024/48/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.9-т "Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 02 дугаар сарын 15-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийлгэнэ" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт хуулийн хугацаанд ирүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын захирал /Б.Түмэн-Өлзий/, ерөнхий нягтлан бодогч /Г.Төрбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ГАНБААТАР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 дугаар сарын 15 № 428/А0130081

Улаанбаатар хот

СНАГ - 2024/48/ИА - СТА - ТОВ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түрээсийн гэрээгээр "Монгол" уран сайхны кинонд ашиглах жижиг хэрэгсэл, хувцас эд зүйлсийг ашиглуулсан ч эртний хийцийн эмээлийг түрээслэгч хүлээлгэн өгөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.8-т "байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм, журмыг баримтлаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Түрээсийн гэрээгээр "Монгол" уран сайхны кинонд ашиглах жижиг хэрэгсэл, хувцас эд зүйлсийг ашиглуулсан ч эртний хийцийн эмээлийг түрээслэгч хүлээлгэн өгөөгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 3 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Монгол кино нэгтгэл" ТӨҮГ-ын захирал /Б.Түмэн-Өлзий/, ерөнхий нягтлан бодогч /Г.Төрбат/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Д.ЭНХДАЛАЙ
М.ГАНБААТАР